

**Кирилл бичгийн зөв бичих дүрмүүдэд
эргэх холбоо үүсэх нь**

Намсрайн ДАВААСҮРЭН*

Монгол Улс, Улаанбаатар, Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн
Багийн сургуулийн Монгол хэл, нийгмийн ухааны тэнхим

Received: April 15, 2025 | **Accepted:** September 29, 2025 | **Published:** October 15, 2025

***Хураангуй:** Кирилл бичгийн зөв бичих дүрэм нь харилцан уялдаа бүхий тогтолцоо болохыг зөв бичих дүрмүүдийн хооронд үүсэх гадаад, дотоод интеграц баталж байна. Зөв бичих дүрмийг ийнхүү интеграцчилан таниулах явцад зарим дүрмийг заахад бусад дүрэм дахин давтагдах өвөрмөц зүй тогтол ажиглагдсан юм. Үүнийг “зөв бичих дүрэмд үүсэх эргэх холбоо” гэж нэрлэсэн бөгөөд энэ нь хэлний жишээгээр нотлогдож байна. Энэхүү өвөрмөц зүй тогтол нь зөв бичих дүрэм бол “цөөн хэдэн дүрмийн цуглуулга” биш, нарийн уялдаа холбоо бүхий тогтолцоо болохыг баталж байна.*

***Түлхүүр үг:** хэл, тогтолцоо, зөв бичих дүрэм, давтамж, уялдаа, эргэх холбоо*

**The Formation of Rotational Connection
in Cyrillic Spelling Rules**

DAVAASUREN Namsrai*

Department of Mongolian Language and Social Sciences, Teachers School,
Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia

***Abstract:** One of the pieces of evidence that the Cyrillic orthography constitutes a coherent system is the internal and external integration of its rules. During the*

* © Н.Даваасүрэн, 2025

Email: davaasuren.n@msue.edu.mn



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license.

application of these spelling rules, a unique pattern was observed: when certain rules were taught, other related rules were repeated. The research shows that when one grammatical rule is introduced, related rules are repeated 2–6 times, forming a kind of “rotational connection” between them. This pattern demonstrates that spelling is not merely a “collection of a few rules,” but rather a complex, interconnected system.

Keyword: language, system, correct spelling, frequency, integration, rotational connection

1. Удиртгал

Хэл нь оюун ухаан, танин мэдэхүйн чухал зэвсэг, нийгмийн түүх, туршлагыг баяжуулан өвлүүлэгч, хүнийг нийгэмшүүлэх хэрэгсэл болдог бөгөөд эх хэлээ сурч эзэмших, сургаж эзэмшүүлэх нь улс үндэстэн, нийгэм, бие хүний хувьд амьдралын зайлшгүй хэрэгцээ мөн. Энэхүү хэрэгцээг хангахад утга зохиолын хэл, түүний нэгэн хэлбэр болох бичгийн хэл нэн чухал үүрэг гүйцэтгэдэг. Зөв бичих нь бичгийн соёлтой хүний нэг шалгуур болсоор ирсэн бөгөөд үүнийг утга зохиолын хэлэнд зөв бичих зүйн хэм хэмжээгээр тогтоон, зөв бичих дүрмийн дагуу бичиж сурах, сургахыг монгол хэлний сургалтын нэг зорилт болгосоор ирсэн юм.

Нөгөө талаас эх хэлний чадамж нь 21-р зууны суралцагчийн эзэмших чадварын нэг болохыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч, Европын Парламент, Боловсролын зөвлөлийн 2016 оны 12-р сард баталсан санал зөвлөмжид “насан туршдаа суралцах найман үндсэн чадамжийн нэгээр “эх хэл дээрээ харилцах” чадамж”-ийг нэрлэсэн бол 2020 оны багшлахуйн ба суралцахуйн чиг хандлагыг тандан судалсан судлаачдын баг “мэдлэгт суурилсан эдийн засаг бүхий технологигсон нийгэмд амьдрахад эзэмших шаардлагатай уян чадвар (soft skills)-ын нэгээр “ам, бичгээр өндөр түвшинд харилцах чадвар” -ыг дурджээ. (2018:18)

Хүн төрөлхтний хэл нь давхарлан шаталж тогтсон нэгжүүдтэй, бүхэл бүтэн тогтолцоо юм. Эрдэмтэн Д.Цэрэнпилийн тодорхойлсончлон “Хэлийг сурч эзэмшихдээ салангид биш, тэдгээрийн хоорондох холбоо харьцаанд буюу хэлний өнгөн ба гүн бүтцийн холбоо хамааралд авч үзэх нь зүйтэй. Хэлний бүрэн мэдлэг нь мэдлэгүүдийн харилцан үйлчлэл дээр тогтдог бөгөөд хэлний нэгжүүд тус тусдаа ангид, салангид зүйл биш, харин түүнтэй сүлжилдсэн холбоонд байж, салбар хэсгүүдийн харилцан уялдааг тодорхой харуулдаг” (2011:70) Хэлний өнгөн бүтэц болох бичиг, түүний зөв бичих зүй тогтол ч мөн тогтолцоот чанартай тухай эрдэмтэн Ж.Бат-Ирээдүй, Ц.Дамдинсүрэн, А.Лувсандэндэв, Б.Бямбасүрэн, Ц. Оюун нарын судлаачид тэмдэглэсэн байдаг. Хэлний тогтолцооны тухай эрдэмтдийн саналыг нэгтгэвэл, хэлний нэгжүүдийн харилцан хамаарал, харилцан бие биеэ нөхцөлдүүлэх харьцаа нь энэхүү тогтолцооны гол амин сүнс болдог байна. (Нансалмаа, 2011:28) Мөн “хэлний элементүүдийг ганц нэгээр нь

цувуулан, гадна талаас нь тоочин тайлбарлахын оронд тэдгээрийн хооронд байгаа амьд хэлхээ холбоо харьцааг тогтоох нь үр дүнтэй” (Нямсүрэн, 1974:35)

Академич Ш.Лувсанвандан энэ тухайд “ ... Аман хэл нь маш нарийн олон давхарласан системд түшиглэж, хүмүүсийн харилцах хэрэглүүр болдог бол түүнийг үсгээр буулгасан бичгийн хэл ч мөн өөрийн өвөрмөц системд түшиглэж, харьцахын хэрэглүүр болно. Хэлний авиаг үсэгтэй нь харьцуулан судлах нь аман хэлийг бичгийн хэлтэй нь харьцуулан судлахад чухал холбогдол учиртай юм” (1972:16) гэжээ.

Германы эрдэмтэн В.Хумбольдтын дэвшүүлсэн хэлний тогтолцооны онолын гол мөн чанар болох хэлний нэгжүүдийн харилцан хамаарал, харилцан бие биеэ нөхцөлдүүлэх харьцааг зөв бичих зүйд авч үзэн, кирилл бичгийн зөв бичих дүрмийн тогтолцоот чанарт түшин, зөв бичих зарим дүрэмд үүсэх эргэх холбоог тодорхойлох нь суралцагчдад тухайн зүйлийн талаар илүү зөв, илүү өргөн хүрээтэй, гүн гүнзгий мэдлэг эзэмшихэд дэмжлэг үзүүлэх юм. Түүнчлэн хэлний энэхүү тогтолцоот чанарыг эх хэлний сургалтад нэвтрүүлэн, суралцагчдад таниулахад монгол хэлний болоод бага ангийн багш нарын үүрэг оролцоо нэн чухал.

Кирилл бичгийн зөв бичих зүйн сургалтад томоохон хувь нэмэр оруулсан багш, судлаач Б.Осор “...Зөв бичүүлж сургахын тулд уг үгийг яаж хэлдэг нь аманд хэвших, чихэнд хоногшиж, яаж бичдэг нь гарт нь орохоор дасгал дадлага хийх хэрэгтэй. Үүний тулд зөв бичих дүрмээ сайн таниулж, нэг дүрмийн жишээг олон үгээр дахин дахин бичүүлэх, адил төстэй үг, ойролцоо дүрмийг харьцуулсан дасгал олныг хийлгэж, зөв бичих дүрмийг ухамсартай хэрэглэдэг болгох хэрэгтэй” (1973:4) гэж зөвлөжээ. Түүнчлэн МУГБ Д. Баяртогтох “...ЕБС-д зөв бичих дүрэм заахад гарч буй нэг том алдаа нь нэгж хугацаанд нэг орон зайд, хамт заах зүй тогтолтой сэдвийг хэсэглэн тасдаж, сурагчдад системтэй мэдлэг өгч чадахгүй байгаа явдал” болохыг онцолсон байна.

Эрдэмтэн Ц. Оюун “...Кирилл бичгийн зөв бичих дүрэм шаталсан тогтолцоо бүхий, бүхэллэг шинжтэй. Зөв бичих дүрэм бүхэлдээ их нэгж, тэр доторх авиа зүй, үг зүй, өгүүлбэр зүйд холбогдох дүрмүүд дунд нэгж, тэдгээр дунд нэгж бүрд багтах дүрмийн зүйлүүд бага нэгж болно.” (2020:101) хэмээн тодорхойлжээ.

Энэ бүхнээс үзвэл өнөөгийн зөв бичих зүйн сургалтад агуулга, арга зүйн шинэчлэл зайлшгүй болох нь тодорхой байна. Судлаач, арга зүйчдийн зөвлөснөөр зөв бичих дүрмийн ухамсартай гүн бат мэдлэг олгох нь зөв бичиж сурахын үндэс болох тул зөв бичих дүрмийн дотоод мөн чанарыг олон талаас нь нарийвчлан авч үзэх нь зүйтэй. Бүр тодруулбал, зөв бичих дүрмүүдийг харилцан хамааралд нь, эргэх холбоонд нь авч үзэх нь суралцагчдад зөв бичих дүрмийн гүн бат мэдлэг эзэмшин, зөв бичих чадвараа сайжруулах боломж олгохын хамт багшийн ажлын ачааллыг багасгах, арга зүйг дэмжих ач холбогдолтой.

2. Судалгааны арга зүй

Уг асуудлыг авч үзэхдээ хэлний нэгжүүдийн уялдаа холбоог тогтоох ассиоцацийн аргыг кирилл бичгийн зөв бичих дүрмүүдийн хоорондын харилцан хамаарлыг тодруулахад, тайлбарлах аргыг кирилл бичгийн зөв бичих дүрмүүдийн хооронд үүсэх эргэх холбоог хэлний жишээгээр нотлоход тус тус ашиглав.

3. Кирилл бичгийн зөв бичих дүрэмд эргэх холбоо үүсэх нь

Шинжлэх ухаан технологи асар хурдацтай хөгжиж буй өнөө үед сургалтын агуулгыг цөм агуулгаар нь багцлан хураангуйлж, оновчтой системчлэх хэрэгцээ бий болж байна. Ийнхүү сургалтын агуулга, арга зүйг интеграцчилан, тодорхой нэг асуудал, үзэгдлийн аль нэгийг үндэс болгон, хичээлийн агуулгыг эрчимтэй, цогц байдлаар төлөвлөх нь суралцагчдад асуудлыг олон талт байдлаар ойлгох боломж олгоно. Түүнчлэн хэлийг хэрэглээ болгохын тулд сургалтын агуулга нягт уялдаа бүхий цомхон, цөм шинжтэй байх нь суралцагчдын сурахуйг хөнгөвчлөх, цаг хэмнэх, улмаар бүтээлч үйлээр нь чадваржуулах боломж олгодог олон давуу талтай юм.

Гэвч өнөөгийн сургалтын агуулга нь өөр хоорондоо амин холбоотой ухагдахуунуудыг нэг нэгээр нь цувуулан, салангид байдлаар тусгасан, агуулгын дидактик нэгжийг хэт жижиглэх чиглэл зонхилсон, суралцагчдын эзэмшсэн мэдлэгийн бүхэл бүтэн, тогтолцоот, эмх цэгцтэй, үндэслэлтэй, ой ухаанд тогтвортой хадгалагдан, түргэн сэргэх гол чанарууд алдагдах зэрэг дутагдал байсаар байна. (2016:100)

Нөгөө талаас суралцагч шинэ мэдээллийг боловсруулах үед уг мэдээлэлтэй төстэй мэдлэг нь түүний урт хугацааны санах ойгоос сэргэж, өмнө нь байсан буруу, зөв мэдлэг эмхлэгдэж, өмнөхөөсөө илүү зөв, илүү цэгцтэй мэдлэгийн бүтэц урт хугацааны санах ойд хадгалагдах боломжтой болно. Ийнхүү тухайн зүйлийн талаар илүү зөв, илүү өргөн хүрээтэй, гүн гүнзгий мэдлэгтэй болж чадах эсэх нь багшийн арга зүйгээс шалтгаалдгийг ч судлаачид тэмдэглэсэн байна. Бид, энэхүү онцлогийг харгалзан, суралцагчдын зөв бичих дүрмийн мэдлэгийг цэгцлэх, дотоод мөн чанарыг ухааруулахын тулд ийнхүү нарийвчлан үзсэн бөгөөд энэ нь суралцагчдыг зөв бичих дүрмийн багтай мэдлэгтэй болж, зөв бичих чадварт суралцахын үндэс болох юм.

Тиймээс аль ч шинжлэх ухааны зүй тогтлыг заахдаа юмс үзэгдэл, ухагдахууны дотоод нарийн холбоонд түших нь нэн чухал. Энэхүү нарийн зүй тогтлыг зөв бичих зүйн сургалтад харгалзан үзэх шаардлагатайг судлаач, арга зүйч багш нар тэмдэглэсэнд үндэслэн, кирилл бичгийн зөв бичих дүрмүүдэд үүсэх уялдаа холбоог тодруулах судалгаа хийсэн юм. Судалгааны явцад тухайн дүрэмтэй уялдаа холбоо үүсгэж буй зарим дүрмийн аль нэгийг таниулахад бусад дүрэм дахин давтагддаг өвөрмөц зүй тогтол ажиглагдав. Энэхүү өвөрмөц зүй тогтлыг “эргэх холбоо” гэж нэрлэсэн бөгөөд уг зүй тогтлыг тодорхойлсноор суралцагчид зөв бичих дүрмийг

“хоосон” цээжлэх биш, дүрмийн системтэй, ухамсартай мэдлэг эзэмшинэ.

Юуны өмнө “эргэх холбоо” үгийн утгыг лавлан үзвэл нийлмэл үгийн хэлбэрээр тохиолдохгүй, харин “эргэх”, “холбоо” гэх тус тусын утгаар орсон байх ба утгыг тодруулах үүднээс холбоо үг, хоршоо үг хэрхэн үүссэнийг нягталлаа. Үүнд:

Я. Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь (1966)

холбоо- юмыг хооронд нь холбосон зүйл; харилцаа хэлхээ; холбоо харилцаа [хоршоо]

эргэх - орчих, тойрох, хөдөлгөөн хийх, буцах, эгэх

Монгол хэлний их тайлбар толь (<https://mongoltoli.mn/search.php>)

холбоо -1. Юмыг хооронд нь холбосон зүйл, авцалдаа холбоо [хоршоо] (аливаа юмны хоорондоо харилцан уялдаж холбогдсон нь), холбоо хэлхээ ~ хэлхээ холбоо [хоршоо] (юмны харилцаа хамаарал, сүлбээ), уялдаа холбоо [хоршоо] (юмны харилцан нөхцөлдсөн, холбогдсон байдал)

эргэх - 1. орчих, өнхрөх 2. буцах, эгэх, эргэх тойрох [хоршоо] (юмыг тойрох, орчих)

Эндээс үзвэл, “эргэх холбоо” хэмээх холбоо үгийн утгыг “аливаа юмсын хамаарал дахин буцаж эгэх” гэж утгаар ойлгож болох ба зөв бичих зүйн хувьд “харилцан уялдаа холбоо бүхий зарим дүрмийг дахин буцаж (эргэж) тайлбарлах” гэсэн утгаар авч үзэж байна.

Кирилл бичгийн зөв бичих дүрмийн хооронд “эргэх холбоо” хэрхэн үүсэхийг “Эгшигт гийгүүлэгчийн дүрэм” (§15), “Заримдаг гийгүүлэгчийн дүрэм” (§17), ‘ж, ч, ш’ гийгүүлэгчийн дараах эгшгийг бичих дүрэм” (§26), “-ж, -ч нөхцөлийг бичих дүрэм” (§39), “Хамааруулах ‘-х’ дагаврыг бичих дүрэм” (§43)-ээр тус тус жишээлэн, тайлбарлая. Эдгээрээс “Эгшигт гийгүүлэгчийн дүрэм” (§15), “Заримдаг гийгүүлэгчийн дүрэм” (§17)-ээр үгийн язгуур, үндсэнд залгавар залгахад эгшиг бичих эсэх, балархай эгшгийг гээх эсэх, зөөлний тэмдэг солигдох эсэх зэрэг олон дүрмийн мөн чанарыг тайлбарлах суурь болдог. Түүнчлэн ЕБС-ийн сургалтын хөтөлбөр, сурах бичигт тусгаагүйгээс олон нийтийн дунд “дараахи, удаахь, доторхийг, засч, нисч” гэх мэтээр буруу бичсээр байгаа үгсийг бичих дүрэм буюу “ -ж, -ч нөхцөлийг бичих дүрэм” (§39), “Хамааруулах ‘-х’ дагаврыг бичих дүрэм” (§43)-ийг зориудаар сонгон авсан болно.

Жишээ 1. “Эгшигт гийгүүлэгчийн дүрэм” (§16), “Үйл үг бүтээх ‘-л’ дагаврын дүрэм” (§38), “Зөөлний тэмдэг солигдох дүрэм” (§32)-д эргэх холбоо үүсэх нь

“монгол баавар” гэсэн үгэнд орсон долоон гийгүүлэгч үгэнд орохдоо өмнөө ба хойноо аль тод хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичигдэнэ.” (§16), “Эгшигт гийгүүлэгчээр төгссөн үгэнд ‘-л’ дагаврыг залгахдаа зохих балархай эгшгийг ард нь бичнэ.” (§38.1), “Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд ‘-л’ дагаврыг залгахдаа зохих балархай эгшгийг өмнө нь бичнэ.” (§38.2), “Зөөлний тэмдгээр

төгссөн үгэнд эгшигт гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад зөөлний тэмдгийг сольж, ‘и’ болгоно.” (§32.2) дүрмүүдийн хооронд “эргэх холбоо” үүсэж байгааг хэлний жишээ нотолж байна. Үүнийг дэлгэрэнгүй тайлбарлая.

I. “монгол баавар” гэсэн үгэнд орсон долоон гийгүүлэгч үгэнд орохдоо өмнөө ба хойноо аль тод хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичигдэнэ.” (§16) дүрмийг “Зөөлний тэмдгээр төгссөн үгэнд “-л” дагавар залгахдаа зөөлний тэмдгийг ‘и’ болгоод, ‘-л’ дагаврыг шууд залгана.” (§38.3), “Зөөлний тэмдгээр төгссөн үгэнд эгшигт гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад зөөлний тэмдгийг сольж, ‘и’ болгоно.” (§32.2) гэсэн хоёр дүрэмтэй холбон тайлбарлана. Жишээ нь:

суурь+л= суурил

1. ‘-л’ дагаврыг яагаад эгшигтэй бичихийг “монгол баавар” гэсэн үгэнд орсон долоон гийгүүлэгч үгэнд орохдоо өмнөө ба хойноо аль тод хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичигдэнэ.” (§16) дүрмээр тайлбарлана.
 2. Зөөлний тэмдэг яагаад ‘и’ болж солигдсоныг “Зөөлний тэмдгээр төгссөн үгэнд эгшигт гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад зөөлний тэмдгийг сольж, ‘и’ болгоно.” (§32.2) дүрмээр тайлбарлана.
 3. “-л” дагаврын өмнө яагаад ‘и’ эгшиг бичсэнийг “Зөөлний тэмдгээр төгссөн үгэнд ‘-л’ дагавар залгахдаа зөөлний тэмдгийг ‘и’ болгоод, ‘-л’ дагаврыг шууд залгана.” (§38.3) дүрмээр тайлбарлана.
- II. “Зөөлний тэмдгээр төгссөн үгэнд эгшигт гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад зөөлний тэмдгийг сольж, ‘и’ болгоно.” (§32.2) дүрмийг “монгол баавар” гэсэн үгэнд орсон долоон гийгүүлэгч үгэнд орохдоо өмнөө ба хойноо аль тод хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичигдэнэ.” (§16), “Зөөлний тэмдгээр төгссөн үгэнд ‘-л’ дагавар залгахдаа зөөлний тэмдгийг ‘и’ болгоод ‘-л’ дагаврыг шууд залгана.” (§38.3) гэх хоёр дүрэмтэй холбон тайлбарлана. Жишээ нь:

суурь+л= суурил


1. Зөөлний тэмдэг ‘и’ болж солигдсоны учрыг “Зөөлний тэмдгээр төгссөн үгэнд эгшигт гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад зөөлний тэмдгийг сольж, ‘и’ болгоно.” (§32.2) дүрмээр тайлбарлана.
 2. ‘-л’ дагаврын өмнө нь яагаад эгшиг бичих ёстойг “монгол баавар” гэсэн үгэнд орсон долоон гийгүүлэгч үгэнд орохдоо өмнөө ба хойноо аль тод хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичигдэнэ.” (§16) дүрмээр тайлбарлана.
 3. ‘-л’ дагаврын өмнө яагаад ‘и’ эгшиг бичсэнийг “Зөөлний тэмдгээр төгссөн үгэнд ‘-л’ дагавар залгахдаа зөөлний тэмдгийг ‘и’ болгоод, ‘-л’ дагаврыг шууд залгана.” (§38.3) дүрмээр тайлбарлана.
- III. “Зөөлний тэмдгээр төгссөн үгэнд ‘-л’ дагаврыг залгахдаа зөөлний тэмдгийг ‘и’ болгоод, ‘-л’ дагаврыг шууд залгана.” (§38.3) дүрмийг ойлгохдоо (тайлбарлахдаа) “монгол баавар” гэсэн үгэнд орсон долоон гийгүүлэгч үгэнд орохдоо өмнөө ба хойноо аль тод хэлэгдэх талдаа заавал эгшигтэй

бичигдэнэ.” (§16), “Зөөлний тэмдгээр төгссөн үгэнд эгшигт гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад зөөлний тэмдгийг сольж, ‘и’ болгоно.” (§32.2) гэсэн хоёр дүрэмтэй холбон тайлбарлана. Үүнийг “суурь+л=суурил” үгээр жишээлэн тайлбарлая. Жишээ нь:

суурь+л= суурил

1. Яагаад “-л” дагаврыг залгахад зөөлний тэмдэг ‘и’ болсныг “Зөөлний тэмдгээр төгссөн үгэнд ‘-л’ дагавар залгахдаа зөөлний тэмдгийг ‘и’ болгоод, ‘-л’ дагаврыг шууд залгана.” (§38.3) дүрмээр тайлбарлана.
2. ‘-л’ дагаврын өмнө нь яагаад эгшиг бичих ёстойг “монгол баавар” гэсэн үгэнд орсон долоон гийгүүлэгч үгэнд орохдоо өмнөө ба хойноо аль тод хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичигдэнэ.” (§16) дүрмээр тайлбарлана.
3. Яагаад зөөлний тэмдэг ‘и’ болж солигдох ёстойг “Зөөлний тэмдгээр төгссөн үгэнд эгшигт гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад зөөлний тэмдгийг сольж, ‘и’ болгоно.” (§32.2) дүрмээр тайлбарлана.

Ийнхүү I дүрмийг ойлгохдоо (тайлбарлахдаа) II, III дүрмийг ойлгоно. (тайлбарлана.) Харин II дүрмийг ойлгохдоо (тайлбарлахдаа) I, III дүрмийг ойлгоно. (тайлбарлана.) III дүрмийг ойлгохдоо (тайлбарлахдаа) I, II дүрмийг ойлгоно. (тайлбарлана.) (Зураг 1.)



Зураг 1. “Эгшигт гийгүүлэгчийн дүрэм” (§16)-д эргэх холбоо үүсэх нь

Зөв бичих зарим дүрмийн хооронд үүсэж буй энэхүү зүй тогтлыг “Эгшигт гийгүүлэгчийн дүрэм”-ээр жишээлэн, хүснэгтээр үзүүлье. (Хүснэгт 1.) Жич: Сумаар эргэх холбоог, тоогоор дүрмийн давтамжийг тэмдэглэв.)

Хүснэгт 1. “Эгшигт гийгүүлэгчийн дүрэм” (§15)-д үүсэх эргэх холбоо

Зүйл	Дүрэм	Жишээ	Эргэх холбоо үүсгэх дүрэм
Эгшигт гийгүүлэгчийн дүрэм (§ 16)	Эгшигт гийгүүлэгч үгэнд орохдоо өмнөө ба хойноо аль тод хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичигдэнэ. (§16)	цэг+л= цэгЛЭ...	Эгшигт гийгүүлэгчээр төгссөн үгэнд залгахдаа зохих балархай эгшгийг ард нь бичнэ. (§38.1) → 7+Л=Лэ (1)
		ах+л= ахЛЛ...	Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд залгахдаа зохих балархай эгшгийг өмнө нь бичнэ. (§38.2) → 9+Л=эЛ (1)
		суурЬ+л= суурИЛ...	Зөөлний тэмдгээр төгссөн үгэнд ‘-л’ дагаврыг залгахдаа зөөлний тэмдгийг ‘и’ болгоно. (§38.3) → Ы+Л=И (1)
			Зөөлний тэмдгээр төгссөн үгэнд эгшигт гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахдаа зөөлний тэмдгийг ‘и’ болгоно. (§32.2) → Ы+7=И (1)
		ач+л= аЧИЛ...	Эр, эм ямар ч үгийн дунд ‘ж, ч, ш’ гурвын дараа балархай эгшиг бичих шаардлага гарвал дандаа ‘и’ эгшиг бичнэ. (§27.2) → Үгийн дунд ж, ч, ш +И (1)
Үйл үг бүтээх ‘-л’ дагаврын дүрэм (§ 38)	Эгшигт гийгүүлэгчээр төгссөн үгэнд залгахдаа зохих балархай эгшгийг ард нь бичнэ. (§38.1)	цэг+л= цэгЛЭ, ам+л= амЛА...	Эгшигт гийгүүлэгч үгэнд орохдоо өмнөө ба хойноо аль тод хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичигдэнэ. (§16) → Э7Э (2)
	Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд залгахдаа зохих балархай эгшгийг өмнө нь бичнэ. (§38.2)	бэж+л= бэхЭЛ, багц+л= багШИЛ...	1.Эгшигт гийгүүлэгч үгэнд орохдоо өмнөө ба хойноо аль тод хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичигдэнэ. (§16) → Э7Э (3) 2.Эр, эм ямар ч үгийн дунд ‘ж, ч, ш’ гурвын дараа балархай эгшиг бичих шаардлага гарвал дандаа ‘и’ эгшиг бичнэ. (§27.2) → Үгийн дунд ж, ч, ш +И (2)
	Зөөлний тэмдгээр төгссөн үгэнд залгахдаа зөөлний тэмдгийг “и” болгоно. (§38.3)	зоорЬ+л=зоорИЛ, амЬ+л=амИЛ,...	1.Эгшигт гийгүүлэгч үгэнд орохдоо өмнөө ба хойноо аль тод хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичигдэнэ. (§16) → Э7Э (4) 2.Зөөлний тэмдгээр төгссөн үгэнд эгшигт гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад зөөлний тэмдэг “и” болж солигдоно. (§32.2) → Ы+Л=И (2)

ж, ч, ш гийгүүлэгчийн дараах эгшгийг зөв бичих дүрэм (§ 27)	Эр, эм ямар ч үгийн дунд ‘ж, ч, ш’ гурвын дараа балархай эгшиг бичих шаардлага гарвал дандаа ‘и’ эгшиг бичнэ. (§27.2) Үгийн дунд ж, ч, ш +И (1)	$\begin{matrix} \text{Ч} + \text{л} = \text{эмЧИЛ} \\ \text{багш} + \text{л} = \text{багШИЛ} \end{matrix}$	1.Эгшигт гийгүүлэгч үгэнд орохдоо өмнөө ба хойноо аль тод хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичигдэнэ. (§16) → ЭГЭ (5) 2.Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд ‘-л’ дагаврыг залгахдаа зохих балархай эгшгийг өмнө нь бичнэ. (§38.2) → 9+Л=ЭЛ (3)
Зөөлний тэмдэг солигдох дүрэм (§ 32)	Зөөлний тэмдгээр төгссөн үгэнд эгшигт гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад зөөлний тэмдэг ‘и’ болж солигдоно. (§32.1) Ь+7=И (2)	$\begin{matrix} \text{зoor} \text{Ь} + \text{л} = \text{зoorИЛ} \\ \text{суур} \text{Ь} + \text{л} = \text{суурИЛ} \end{matrix}$	1.Эгшигт гийгүүлэгч үгэнд орохдоо өмнөө ба хойноо аль тод хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичигдэнэ. (§16) → ЭГЭ (6) 2.Зөөлний тэмдгээр төгссөн үгэнд ‘-л’ дагаврыг залгахдаа зөөлний тэмдгийг ‘и’ болгоно. (§38) → Ь+Л=И (2)

Ийнхүү “Эгшигт гийгүүлэгчийн дүрэм” (§15), “Үйл үг бүтээх“-л” дагаврын дүрэм (§37), “Зөөлний тэмдэг солигдох дүрэм” (§31), “ж, ч, ш –ийн дараах эгшгийг бичих дүрэм” (§26) -ийн аль нэгийг заахад бусад дүрэм 2-6 удаа давтагдан, “эргэх холбоо” үүсэж байна.

Жишээ 2. Хамааруулах ‘-х’ дагаврыг бичих дүрэм” (§43), “Заримдаг гийгүүлэгчийн дүрэм” (§18), “ж, ч, ш-ийн дараах эгшгийг бичих дүрэм” (§27)-д эргэх холбоо үүсэх нь

“Хамааруулах ‘-х’ дагаврыг эр, эм ямар ч үгэнд зөөлний тэмдгийг ч, “и” үсгийг ч бичихгүй” (§43) болон “Эр, эм ямар ч үгийн дунд орсон “ж, ч, ш” гурвын дараа балархай эгшиг бичих шаардлага гарвал дандаа ‘и’ эгшиг бичнэ.” (§27.3), “Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд заримдаг гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад сүүлийн заримдаг гийгүүлэгч өмнөө юм уу хойноо аль хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичнэ.” (§18) дүрмийн хооронд “эргэх холбоо” үүснэ. Үүнд:

I.“Хамааруулах ‘-х’ дагаврыг эр, эм ямар ч үгэнд зөөлний тэмдгийг ч, ‘и’ үсгийг ч бичихгүй.” (§43) дүрмийг “Эр, эм ямар ч үгийн дунд орсон ‘ж, ч, ш’ гурвын дараа балархай эгшиг бичих шаардлага гарвал дандаа ‘и’ эгшиг бичнэ.” (§27.3), “Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд заримдаг гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад сүүлийн заримдаг гийгүүлэгч өмнөө ба хойноо аль хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичнэ.” (§18) дүрэмтэй холбон тайлбарлана. Жишээ нь:

цааиш+х= цааиших

1. “-х” дагаврын ард яагаад ‘и’ ба ‘ь’ бичээгүйг “Хамааруулах ‘-х’ дагаврыг эр, эм ямар ч үгэнд зөөлний тэмдгийг ч, ‘и’ үсгийг ч бичихгүй.” (§43) дүрмээр тайлбарлана.

2. Яагаад ‘х’ гийгүүлэгчийн өмнө эгшиг бичсэнийг учрыг “Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд заримдаг гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад сүүлийн заримдаг гийгүүлэгч өмнөө юм уу хойноо аль хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичнэ.” (§18) дүрмээр тайлбарлана.
3. Яагаад заавал ‘и’ эгшиг бичиж байгааг “Эр, эм ямар ч үгийн дунд орсон ‘ж, ч, ш’ гурвын дараа балархай эгшиг бичих шаардлага гарвал дандаа ‘и’ эгшиг бичнэ.” (§27.3) дүрмээр тайлбарлана.

II. “Эр, эм ямар ч үгийн дунд орсон ‘ж, ч, ш’ гурвын дараа балархай эгшиг бичих шаардлага гарвал дандаа ‘и’ эгшиг бичнэ.” (§27.3) дүрмийг “Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд заримдаг гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад сүүлийн заримдаг гийгүүлэгч өмнөө юм уу хойноо аль хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичнэ.” (§18), “Хамааруулах ‘-х’ дагаврыг эр, эм ямар ч үгэнд зөөлний тэмдгийг ч, ‘и’ үсгийг ч бичихгүй.” (§43) дүрэмтэй холбон тайлбарлана. Жишээ нь:

цааиш+х= цааиших

1. Яагаад ‘х’ гийгүүлэгчийн өмнө эгшиг бичсэнийг “Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд заримдаг гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад сүүлийн заримдаг гийгүүлэгч өмнөө юм уу хойноо аль хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичнэ.” (§18) дүрмээр тайлбарлана.
2. ‘-х’ дагаврын ард яагаад ‘и’ ба ‘ь’ бичээгүйг “Хамааруулах ‘-х’ дагаврыг эр, эм ямар ч үгэнд зөөлний тэмдгийг ч, ‘и’ үсгийг ч бичихгүй.” (§43) дүрмээр тайлбарлана.
3. Яагаад заавал “и” эгшиг бичсэнийг “Эр, эм ямар ч үгийн дунд орсон ‘ж, ч, ш’ гурвын дараа балархай эгшиг бичих шаардлага гарвал дандаа ‘и’ эгшиг бичнэ.” (§27.3) дүрмээр тайлбарлана.


III. “Эр, эм ямар ч үгийн дунд орсон ‘ж, ч, ш’ гурвын дараа балархай эгшиг бичих шаардлага гарвал дандаа ‘и’ эгшиг бичнэ.” (§27.3) дүрмийг “Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд заримдаг гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад сүүлийн заримдаг гийгүүлэгч өмнөө юм уу хойноо аль хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичнэ.” (§18), “Хамааруулах ‘-х’ дагаврыг эр, эм ямар ч үгэнд зөөлний тэмдгийг ч, ‘и’ үсгийг ч бичихгүй.” (§43) дүрэмтэй холбон тайлбарлана. Жишээ нь:

цааиш+х= цааиших

1. Яагаад заавал “и” эгшиг бичсэнийг “Эр, эм ямар ч үгийн дунд орсон ‘ж, ч, ш’ гурвын дараа балархай эгшиг бичих шаардлага гарвал дандаа ‘и’ эгшиг бичнэ.” (§27.3) гэсэн дүрмээр тайлбарлана.
2. Яагаад ‘х’ гийгүүлэгчийн өмнө эгшиг бичсэнийг “Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд заримдаг гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад сүүлийн заримдаг гийгүүлэгч өмнөө юм уу хойноо аль хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичнэ.” (§18) дүрмээр тайлбарлана.

3. ‘-х’ дагаврын ард яагаад ‘и’ ба ‘ь’ бичээгүйг “Хамааруулах ‘-х’ дагаврыг эр, эм ямар ч үгэнд зөөлний тэмдгийг ч, ‘и’ үсгийг ч бичихгүй.” (§43) дүрмээр тайлбарлана.

Ийнхүү I дүрмийг ойлгохдоо (тайлбарлахдаа) II, III дүрмийг ойлгоно. (тайлбарлана.) Харин II дүрмийг ойлгохдоо (тайлбарлахдаа) I, III дүрмийг ойлгоно. (тайлбарлана.) III дүрмийг ойлгохдоо (тайлбарлахдаа) I, II дүрмийг ойлгоно. (тайлбарлана.) (Зураг 2.)



Зураг 4. “Хамааруулах ‘-х’ дагаврыг бичих дүрэм” (§43)-д эргэх холбоо үүсэх нь

Зөв бичих зарим дүрмийн хооронд үүсэж буй энэхүү зүй тогтлыг “-ж, -ч нөхцөлийг бичих нь” (§39) дүрмээр жишээлэн хүснэгтээр үзүүлье. (Хүснэгт 2.) Жич: Сумаар эргэх холбоог, тоогоор дүрмийн давтамжийг тэмдэглэв.)

Хүснэгт 2. “-ж, -ч” нөхцөлийг бичих дүрэм” (§39)-д эргэх холбоо үүсэх нь

Дүрэм	Дүрмийн зүйл	Жишээ	Эргэх холбоо үүсгэх дүрэм, дүрмийн зүйл
Заримдаг гийгүүлэгчийн дүрэм (§ 18)	Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд заримдаг гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад сүүлийн заримдаг гийгүүлэгч өмнөө юм уу хойноо аль хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичигдэнэ. 9+9= Э (1)	Жишээ уншИж, ахь+ж = ахИж... ас+ж = асАж, унш+ж = уншИж, ахь+ж = ахИж...	1.Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд зөвхөн ‘-ж’ бичнэ. (§40.2) 9+Ж (1) 2.Эр, эм ямар ч үгийн дунд ‘ж, ч, ш’ гурвын дараа балархай эгшиг бичих шаардлага гарвал дандаа ‘и’ бичнэ. (§27.2) Үгийн дунд ж, ч, ш +И (1) 3.Зөөлөрсөн заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд заримдаг гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад зөөлний тэмдэг ‘и’ болж солигдоно. (§32.4) 9Б+9=И (1)
‘ж, ч, ш’ гийгүүлэгчийн дараах эгшиг бичих дүрэм (§ 27)	Эр, эм ямар ч үгийн дунд ‘ж, ч, ш’ гурвын дараа балархай эгшиг бичих шаардлага гарвал дандаа ‘и’ эгшиг бичнэ. (§27.3) Үгийн дунд ж, ч, ш +И (2)	Жишээ туурш+ж = тууршИж, түүш+ж = түүшИж...	1.Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд заримдаг гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад сүүлийн заримдаг гийгүүлэгч өмнөө, хойноо эгшигтэй бичигдэнэ. (§18) 9+9=Э (2) 2.Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд зөвхөн ‘-ж’ бичнэ. (§40.2) 9+Ж (2)

“ -ж, -ч” нөхцөлийг бичих дүрэм” (§ 40)	Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд зөвхөн ‘-ж’ бичнэ. (§40.2) 9+Ж (3)	дас+ж = дасАж, унц+ж = унцИж, ахь+ж = ахИж ...	1.Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд заримдаг гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад сүүлийн заримдаг гийгүүлэгч өмнөө юм уу хойноо аль хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичигдэнэ. (§18) 9+᠑=᠑ (3) 2. Эр, эм ямар ч үгийн дунд ‘ж, ч, ш’ гурвын дараа балархай эгшиг бичих шаардлага гарвал дандаа ‘и’ эгшиг бичнэ. (§27.3) Үгийн дунд ж, ч, ш +И (3) 3.Зөөлөрсөн заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд заримдаг гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад зөөлний тэмдэг ‘и’ болж солигдоно. (§32.4) 9ᠪ+9= И (2)
“ Зөөлний тэмдэг солигдох дүрэм” (§ 32)	Зөөлөрсөн заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд заримдаг гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад зөөлний тэмдэг ‘и’ болж солигдоно. (§32.4) 9ᠪ+᠑= И (3)	цахь+ж = цахИж, дохь+ж = дохИж,	1.Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд заримдаг гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад сүүлийн заримдаг гийгүүлэгч өмнөө юм уу хойноо аль хэлэгдэх талдаа эгшигтэй бичигдэнэ. (§18) 9+᠑= ᠑ (4) 2.Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд зөвхөн “-ж” бичнэ. (§40.2) 9+-Ж (4)

Ийнхүү “-ж, -ч нөхцөлийг бичих дүрэм” (§39), “ж, ч, ш гийгүүлэгчийн дараах эгшигийг бичих дүрэм” (§26), “Зөөлний тэмдэг солигдох дүрэм”(§31), “Заримдаг гийгүүлэгчийн дүрэм” (§17)-ийн аль нэгийг заахад бусад дүрмүүд 2-4 удаа давтагдан, тэдгээр дүрмийн хооронд “эргэх холбоо” үүсэж байна.

4. Судалгааны үр дүн

Хэлний тогтолцоот шинж нь ижил төстэй, ялгаатай ойлголтод тулгуурлаж, тэдгээрийн бусад нэгжтэй харьцах дотоод харьцаагаар илрэх бөгөөд энэ нь зөв бичих зүйн хувьд дүрмүүдийн харилцан хамаарал, эргэх холбоогоор тодорхойлогдож, хэлний тодорхой жишээгээр нотлогдож байна. Кирилл бичгийн зөв бичих дүрмийг ийнхүү нарийвчлан авч үзэж байгаа нь агуулгыг хүндрүүлэх биш, гагцхүү хэлний дотоод зүй тогтлыг ухааруулж, зөв бичих дүрэм нь тогтолцоот шинжтэйн нэг баталгаа болох юм. Кирилл бичгийн зөв бичих дүрэмд үүсэж буй энэхүү зүй тогтол буюу “эргэх холбоо”-г тодорхойлох нь суралцагчдад дүрэм бүрийн мөн чанарыг ухаарч, дүрмийн ухамсартай, гүн бат мэдлэг эзэмшихэд дэмжлэг үзүүлэх юм. Улмаар зөв, буруу бичсэн үгийг ялгах, дүрмээр

тайлбарлан засах зэргээр зөв бичих чадвараа сайжруулж, зөв бичих дадал төлөвших үндэс болох юм.

5. Дүгнэлт

1. Кирилл бичгийн зөв бичих дүрмүүдийн хооронд үүсэх энэхүү өвөрмөц зүй тогтол нь зөв бичих дүрэм нь “цөөн хэдэн дүрмийн цуглуулга” биш, харин нарийн уялдаа холбоо бүхий тогтолцоо болохыг нотолж байна.
2. Зөв бичих дүрэмд үүсэх энэхүү “эргэх холбоо”-г нарийвчлан тайлбарласнаар суралцагчид дүрмийн мөн чанарыг ухаарч, дүрмийн гүн бат, эмх цэгцтэй мэдлэг эзэмшинэ.
3. Энэхүү зүй тогтлыг ЕБС-д дүрэм зааж эхлэх тухайн цаг үеэс суралцагчдад хялбаршуулан таниулснаар тэдний зөв бичих дүрмийн мэдлэг, чадварт нь тодорхой ахиц гарна.
4. Харилцан уялдаа бүхий зөв бичих дүрмийг ЕБС-д мөрдөж буй “Бага боловсролын монгол хэлний сургалтын хөтөлбөр”-т (2019) анги бүрд хэсэглэн таниулахаар тусгасан нь суралцагчдын зөв бичих дүрмийн мэдлэг, чадварт сөргөөр нөлөөлөх нэг хүчин зүйл болж байгаад анхаарлаа хандуулах шаардлагатай.

Ном зүй

- Ариунжаргал, Д., Энхтүвшин, С., Ононтуул, О., Базарваань, Д., Мөнхбат, Д.** (2018). *Суралцахуй, суралцахуйн хэв маяг*. Улаанбаатар. Мөнхийн үсэг ХХК [Ariunjargal, D., Enhtuvshin, S., Onontuul, O., Bazarvaani, D., Munhbat, D. *Suraltsahui, suraltsahuin hev mayag* [Learning and Learning Styles]. Ulaanbaatar. Munhiin useg LLC. 2018].
- Баяртогтох, Н.** (2010). *Монгол уг 400 гаруй мянга боловч төгсгөл нь гуравхан янз*. <https://news.mn/r/14254/> [Bayartogtoh, N. *Mongol ug 400 garui myanga bolovch tugsgul ni guravhan yanz* [Over 400,000 Mongolian Words, but Only Three Endings]. Retrieved from <https://news.mn/r/14254/>]
- Лувсанвандан, Ш.** (1972). *Хэл шинжлэлд хийсвэрлэх аргын холбогдох нь*, Хэл зохиол судлал, №15. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар. [Luvsanvandan, Sh. *Khel shinjleld hiisverleh argiin holbogdoh ni* [The Relevance of the Abstraction Method in Linguistics]. Ulaanbaatar: State publishing house. 1972].
- Хэл зохиолын хүрээлэн.** (2016). Монгол хэлний их тайлбар толь. Улаанбаатар: [Khel zohiolyn hureelen. *Mongol helnii ih tailbar toli* [Mongolian Language great Dictionary]. Retrieved from <https://mongoltoli.mn/>]
- МУБИС. Багшийн сургууль** (2016). *Нэгдмэл агуулга, түүний арга зүй*. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК. [MUBIS, Bagshiin surguuli. *Negdmel aguulga, tuunii arga zui* [Unified Content and Its Methodology]. Ulaanbaatar: Munkhiin useg LLC. 2016]

-
- МУБИС, НХУС.** (2020). *Орчин цагийн монгол хэл*. Улаанбаатар: Бит пресс.
[MUBIS.Bagshiin surguuli. *Orchin tsagiin mongol hel* [Modern Mongolian Language].Ulaanbaatar: Bit press LLC. 2020]
- Нансалмаа, Н.** (2011). *Хэл шинжлэлийн судалгааны арга зүй*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Nansalmaa, N. *Hel shijleliin sudalgaanii arga zui* [Linguistic Research Methodology] Ulaanbaatar: Soyombo printing. 2011]
- Нямсүрэн, С.** (1974). *Хэл, хэлэхийн учир*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар. [Nyamsuren, S. *Khel, khelehiin uchir* [Reason of Language and Speech]. Ulaanbaatar: State publishing house.1974]
- Осор, Б., Эрдэнэбаяр, Б.** (1973). *Зөв бичих дүрмээр зүйлчилсэн толь*. Улаанбаатар: Ардын боловсролын яамны хэвлэл. [Osor, B., Erdenebayar, B. *Zuv bichih durmeer zuilchilsen toli* [A Dictionary Arranged by Spelling Rules]. Ulaanbaatar: Publication of the Ministry of Public Education.1973]
- Цэвэл, Я.** (1966). *Монгол хэлний товч тайлбар толь*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо.[Tsevel, Ya. *Mongol helnii tovch tailbar toli* [Concise Dictionary of Mongolian Language]. Ulaanbaatar: State Committee for Press Affairs.1966]
- Цэрэнпил, Д.** (2011). *Түгээмэл хэл зүй ба монгол хэл*. Улаанбаатар: Удам соёл ХХК.[Tserenpil, D. *Tugeemel hel zui ba mongol hel* [Universal Grammar and Mongolian Language] Ulaanbaatar: Udam soyol LLC. 2011].